



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Я.СОДБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2019.11.01 № 1-1/5342
танай _____-ны № _____-т

Хариу өгөх тухай

Танайхаас ирүүлсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228, 232 дугаар тушаалуудыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж дараахь хариуг хүргүүлж байна. Үүнд:

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" /Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам/ 228 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4018 дугаарт бүртгэсэн.

2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны "Журам батлах тухай" /Олон улс, улсын чанартай авто замд хөдөлгөөний эрчмийн тооллого хийх журам/ 232 дугаар тушаал нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан шинжийг агуулаагүй байх тул улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй гэж үзэн мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.3.3-т заасны дагуу буцаан хүргүүлж байна.


Ц.НЯМДОРЖ

8576
2018.11.02

QW



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн сайд
2018 оны 11 сарын 01
өдрийн 4018 дугаар

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн сайд /хуучнаар/-ын 2015 оны 228 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Я.СОДБААТАР

11020002 512417 081912

Бүртгэлийн дугаар 468
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛЬ АР ҮНЭН
Хуучнаар өлгөсөн актын тэргүүн үсэг
2018 оны 10 сарын 18 өдөр

080605

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 10 дугаар сарын 18 ны
өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү журмаар олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн барилга, их засварын ажилд /цаашид “замын барилгын ажил” гэх/ техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ журмыг нэгэн адил мөрдөнө.

1.2. Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээг заавал хэрэгжүүлэх бөгөөд энэхүү журмыг баримтална.

Хоёр. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Зөвлөх нь замын барилгын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төслийн явцын тайлан мэдээ гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2. Зөвлөх нь замын барилгын ажилд энэхүү журмын хавсралтад заасан жишиг маягтыг ашиглах бөгөөд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн гэрээнд өөрөөр заагаагүй бол нэгэн адил ашиглана.

Гурав. Зөвлөхөд тавих шаардлага.

3.1. Зөвлөх нь “Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөлтэй байна.

3.2. Зөвлөх нь Захиалагчийн тавьсан шаардлагыг хангасан бүрэлдэхүүнтэй хяналтын багийг томилж, ажлын талбайд байнга ажиллуулна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан мэргэжилтнийг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд Захиалагчтай зөвшилцөн, зөвшөөрөл авсны үндсэн дээр түүнтэй ижил түвшний мэдлэг боловсрол, туршлагатай хүнийг томилон ажиллуулна.

3.3. Замын барилгын ажилд хяналт тавих Зөвлөх багийн ажилтан нь мэргэжлийн алдаа дутагдал гаргаж, гэрээнд заагдсан ажлыг хариуцах чадваргүй болон инженерийн ёс зүйн хувьд доголдолтой болох нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд тухайн ажилтныг өөрчилж, шаардлага хангасан хүнийг томилж ажиллуулна.

3.4. Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан хяналтын багийн мэргэжилтэн нь зөвхөн тухайн замын барилгын ажилд хяналт тавьж ажиллана.

3.5. Зөвлөх нь зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан замын барилгын ажлын лаборатори болон хэмжилт хийх багаж хэрэгсэл, машин техникээр хангагдсан байна.

3.6. Зөвлөх нь эд хөрөнгийн болон хариуцлагын даатгалд зохих хууль журам, гэрээнд заасны дагуу даатгуулна.

18 10 2018

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Захиалагч нь замын барилгын ажлын зураг төсөл, техникийн шаардлага, батлагдсан төсөв, Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ зэрэг тухайн ажилтай холбоотой баримт бичиг, мэдээллийг техник, технологийн хяналт тавих Зөвлөхөд хүлээлгэн өгнө.

4.2. Зөвлөхийн үйл ажиллагааг хүн/сараар тооцох бөгөөд нөхөн төлөгдөх зардлын хамтаар санхүүжилтийг олгоно. Энэхүү хүн/сарын үнэлгээнд зөвлөхийн ажиллагсдын үндсэн болон нэмэгдэл цалин, томилолтын зардал, бүх төрлийн татвар, хураамж орох бөгөөд нөхөн төлөгдөх зардлын үнэлгээнд тээвэр, ажлын талбайд амьдрах, албан үйл ажиллагаа явуулах байрны болон нийгмийн зардал, техник, технологийн хяналт хийхэд шаардлагатай бусад зардал хамаарна.

4.3. Төслийн үе шатны ажлын хэрэгжилтийн явцаас хамаарч шаардлагатай тохиолдолд Захиалагч нь барилгын ажлын талбайд ажиллах Зөвлөхийн багийн инженер техникийн ажилтны тоо, хүн/сард өөрчлөлт оруулж болно.

4.4. Захиалагч нь замын барилгын ажлын зураг төсөв, техникийн шаардлага болон ажлын явц, үр дүн, гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой Зөвлөхөөс тавьсан асуудлыг шуурхай шийдвэрлэж хариу өгнө.

4.5. Замын барилгын ажлын гэрээний хэрэгжилтийн явцад Зөвлөх нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тухайн ажлыг зураг, төсвийн дагуу холбогдох стандарт, норм, дүрэмд нийцүүлэн чанартай хийж гүйцэтгүүлээгүй тохиолдолд Захиалагч нь Зөвлөхөд төлөх төлбөрийг санхүүжүүлэхээс татгалзаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгаж, биелэлтийг гаргаж ирүүлэх хүртэлх хугацаанд санхүүжилтийг олгохгүйгээр түр зогсооно.

Тав. Зөвлөхийн эрх, үүрэг

5.1. Замын барилгын ажил гүйцэтгэх гэрээг хугацаанд нь чанартай, үр ашигтай гүйцэтгүүлэх болон бусад асуудлаар өөрийн санал, зөвлөмжийг Захиалагчид хүргүүлнэ.

5.2. Замын барилгын ажлын гэрээний хэрэгжилтийн явцад үүссэн аливаа асуудлыг газар дээр нь хугацаа алдахгүйгээр шийдвэрлэх зорилгоор тухайн үе шатны ажлын 10 хувиас ихгүй хэмжээний өртөгтэй ажлыг гэрээний нийт үнийг өсгөхгүйгээр инженерийн оновчтой шийдэл гарган гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тухай Захиалагчид мэдэгдэнэ.


5.3. Зөвлөх нь замын барилгын ажлын чанар байдалд үзлэг хийж, илэрсэн алдаа дутагдлыг засварлуулах албан шаардлага өгнө.

5.4. Зөвлөх нь Захиалагчийн нэрийн өмнөөс ажиллаж, техник технологийн болон чанарын шаардлага хангаагүй ажилд зөвшөөрөл өгч баталгаажуулахгүй байх эрхтэй бөгөөд зөвшөөрөлгүй хийгдсэн ажлыг дахин хийлгэж чанарын шаардлагыг хангуулна.

5.5. Зөвлөх нь замын барилгын ажил хэрэгжилтийн хугацаанд тухайн ажлыг батлагдсан зураг төсөв, норм, норматив, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд өдөр тутам хяналт тавьж, ажлын чанар, гүйцэтгэлийг баталгаажуулан ажлын явцын талаарх мэдээллээр Захиалагчийг хангана.

5.6. Замын барилгын ажлын хэрэгжилтийн явцад үүссэн аливаа зөрчил, дутагдлыг нэн даруй арилгуулж, тухайн ажлыг шаардлагад нийцүүлэн чанартай гүйцэтгүүлнэ.

5.7. Технологийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн чанарын баталгаат хугацаанд гарсан аливаа эвдрэл, гэмтлийг засварлуулах ажилд Зөвлөх нь өөрийн хөрөнгөөр техник, технологийн хяналт тавьж чанартай гүйцэтгүүлнэ.



5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн ажил гүйцэтгэх хүсэлтийн дагуу тухайн ажлыг газар дээр нь шалгаж, шаардлага хангасан тохиолдолд дараагийн үе шатны ажил эхлэх зөвшөөрлийг 24 цагийн дотор олгоно.

5.9. Зөвлөх нь замын барилгын ажлын явц, хэрэгжилтийн талаар 7 хоног тутам Гүйцэтгэгчтэй хамтарсан хурал зохион байгуулан тэмдэглэл хөтөлж, шаардлагатай арга хэмжээг авч Гүйцэтгэгчийн хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллана.

5.10. Зөвлөх нь замын барилгын ажлыг батлагдсан график төлөвлөгөөний дагуу гүйцэтгүүлэх бөгөөд ажлын явц удааширсан, график төлөвлөгөөний биелэлт тасарсан тохиолдолд шалтгааныг тогтоож, хоцрогдлыг нөхөж ажлыг эрчимжүүлэх талаар саналаа боловсруулж Захиалагчид танилцуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

5.11. Зөвлөх нь зам барилгын ажлын батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн саналаа Захиалагчтай зөвшилцөн шийдвэрлүүлнэ.

5.12. Гүйцэтгэгчийн ирүүлсэн санхүүжилтийн хүсэлтийг гэрээнд заасан хугацаанд хянан баталгаажуулна. Санхүүжилтийн хүсэлтэд алдаа гарсан тохиолдолд Гүйцэтгэгчид буцаан засварлуулна.

5.13. Замын барилгын ажлын гэрээг хэрэгжүүлэх талаар төрийн болон орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ханган шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

5.14. Зөвлөх нь тухайн замын барилгын ажилтай холбоотой аливаа маргаан, нэхэмжлэл, хохирлын талаар судалж, тайлбар, дүгнэлт, зөвлөмж гарган Захиалагчид ирүүлнэ.

5.15. Зөвлөх нь төслийн ажлын эхлэлийн, сарын, эцсийн тайланг гэрээнд заасан хугацаанд гаргаж, Захиалагчид албан бичгийн хамт ирүүлнэ. Тайланд хийгдсэн ажлын тоо хэмжээ, ажлын явц, тухайн хугацаанд гарсан аливаа өөрчлөлт, санхүүжилт, цаашид авах арга хэмжээний санал, төлөвлөгөө, холбогдох фото зураг зэрэг мэдээллийг тусгасан байна.

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1. Зөвлөхийн мэргэжилтнүүдийн ур чадвар, санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны улмаас гарсан алдаа, учирсан хохирол нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд Зөвлөхөд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

6.2. Зөвлөх нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, удаа дараа мэргэжлийн алдаа, зерчил, дутагдал гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон тохиолдолд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцлах, тусгай зөвшөөрлийн эрхийг нь түдгэлзүүлэх, цуцлах зэрэг хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг зөрчсөн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



468

18 10 2018
dd




3

Авто зам, замын байгууламжийн барилгын
ажлын техник, технологийн хяналтыг
хэрэгжүүлэх журмын хавсралт

Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн
зөвлөхийн хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын жагсаалт

№	Маягтын нэр	Маягтын дугаар
1	Ажил шалгуулах, зөвшөөрөл авах хүсэлт	Маягт №01
2	Ажил шалгуулах, зөвшөөрөл авах хүсэлтийн нэгдсэн бүртгэл	Маягт №01-01
3	Хяналтын инженерийн албан шаардлага	"Маягт №02
4	Хяналтын инженерийн албан шаардлага, биелэлтийн бүртгэл	Маягт №02-01
5	Талбайн зааварчилгаа	Маягт №03
6	Талбайн зааварчилгаа, биелэлт	Маягт №03-01
7	Талбайн зааварчилгаа, биелэлтийн бүртгэл	Маягт №03-02
8	Гүйцэтгэгч компаний хийж гүйцэтгэсэн ажлын өдрийн мэдээ	Маягт №04
9	Долоо хоногийн мэдээ	Маягт №05
10	Сарын тайлан /тоо хэмжээгээр/	Маягт №06
11	Сарын тайлан /мөнгөн дүнгээр/	Маягт №07
12	График төлөвлөгөөний биелэлт	Маягт №08



АЖИЛ ШАЛГУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ № ...

Барилга объектийн нэр, хүчин чадал:		Огноо:
Захиалагч:	Гүйцэтгэгч:	Хяналт гүйцэтгэгч:


АЖИЛ ШАЛГУУЛАХ ХҮСЭЛТ

Ажил шалгуулах хяналтын инженер:	Замын инженер <input type="checkbox"/>	Гүүр хиймэл байгууламжийн инженер <input type="checkbox"/>
	Материалын инженер <input type="checkbox"/>	Хэмжилтийн инженер <input type="checkbox"/>
Ажлын байршил:	ПК	ПК
Шалгуулах хугацаа:		
Шалгуулах ажлын нэр:		
Тухайн ажилд ашигласан материал:		
Хавсаргасан шинжилгээ, туршилт дүгнэлтийн баримт		

ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ

Зөвшөөрөл хүссэн дараагийн шатны ажлын нэр:				
Ажлын байршил:	ПК	ПК		
Энэ ажилд ашиглах материал:				
Хүсэлт гаргасан:	Хүсэлтийг хүлээн авсан:			
Гарын үсэг:	Гарын үсэг:			
Огноо:	Цаг:	Огноо:	Цаг	
Хяналтын инженерийн дүгнэлт	<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	<input type="checkbox"/>	Зөвшөөрөөгүй
Тайлбар:				
Зөвшөөрөл олгосон:	Гарын үсэг:	Овог, Нэр:	Огноо:	Цаг:
Замын инженер:	_____	_____	_____	_____
Хэмжилтийн инженер:	_____	_____	_____	_____
Материалын инженер:	_____	_____	_____	_____
Хийцийн инженер:	_____	_____	_____	_____
Хянасан:				
Багийн ахлагч:	_____ 468		_____	_____
Зөвшөөрөл хүлээн авсан:				
Гүйцэтгэгчийн инженер:	_____	_____	_____	_____

18 10 *[Signature]* 22



Ажил шалгуулах зөвшөөрөл авах хүсэлтийн бүртгэл №.....

Д/д	Шалгуулах ажлын нэр	Ажил шалгуулах хүсэлтийн		Ажил шалгуулах		Ажил шалгах инженер	Зөвшөөрсөн эсэх		Дүгнэлт тэмдэглэл
		Дугаар	Өгсөн он сар өдөр	он сар өдөр	цаг		+	-	
1	2	3	4	5	6	7	8	9	10
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									

Бүртгэл хөтөлсөн

468
 18 10 2018
 Дорнод

МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ ТЭГВРИЙН ХОГАЛМИН ЯАМ
 ЭХ ХУВЬ
 218 228

ХЯНАЛТЫН ИНЖЕНЕРИЙН АЛБАН ШААРДЛАГА №

Барилга объектийн нэр:	
Гүйцэтгэгч байгууллага:	
Барилгын ажил гүйцэтгэх гэрээний №	
Огноо:	
Албан шаардлагын утга:	Хэрэгжүүлэх хугацаа
Албан шаардлага өгсөн: Хяналтын инженер Албан шаардлага хүлээн авсан: Гүйцэтгэгчийн инженер	

Бүтээгдэхүүний дугаар 468
ХУУЛГААР ҮНЭН
18 10 12

ЗХ ХУВЬ
2018 218

Гүйцэтгэгчид өгсөн албан шаардлага, биелэлтийн бүртгэл №.....

Д/д	Албан шаардлагын утга	Албан шаардлагын		Шаардлагын заалтын тоо	Хүлээн авсан ажилтаны нэр	Биелэлтийн хугацаа		Шаардлагын биелэлт заалтын тоогоор		Биелэлтийн тухай дүгнэлт тэмдэглэл
		Дугаар	өгсөн он сар өдөр			өгөх	өгсөн	биелэсэн	биелээгүй	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1										
2										
3										
4										
5										
6								468		

Бүртгэл хөтөлсөн

ХАШИГАХ ҮНЭМ
 2018 оны 10 сарын 18
Д.м

МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ ТЭГВРИЙН ХЭГ ЭЛИЙН ЯАМ
 ЭХ ХУВЬ
 Санд Торлын нэгжид өгөгдсөн
 дэргт. 2018 оны 228

ТАЛБАЙН ЗААВАРЧИЛГАА №...

Төслийн нэр:

Зөвлөхийн нэр:

Огноо:.....

Гүйцэтгэгчийн нэр:

Цаг:.....

№	Ажлын талбайн байршил	Ажлын нэр төрөл	Гарсан алдаа дутагдал	Өгсөн зааварчилгаа, зөвлөмж	Засварлаж дуусгах хугацаа	Зааварчилгаа өгсөн инженерийн албан тушаал, гарын үсэг	Зааварчилгааг хүлээн авсан гүйцэтгэгчийн инженерийн албан тушаал, гарын үсэг

468

18 10 22

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХОГЖЛИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ


Сайд Төрлийн нэрийн бичгийн дарга *ДТБ* *228*

№ ... ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ ХИЙГДСЭН АЖИЛ, АВСАН АРГА ХЭМЖЭЭ

№	Ажлын талбайн байршил	Ажлын нэр төрөл	Гарсан алдаа дутагдал	Алдаа дутагдлыг засварласан хугацаа	Алдаа дутагдлыг арилгахаар хийгдсэн ажил	Хариуцан ажилласан гүйцэтгэгчийн инженер	Алдаа дутагдал арилгасан байрлал, дүгнэлт	Шалгаж дүгнэсэн инженер

Хянасан: Багийн ахлагч

468



2018 228

Гүйцэтгэгчид өгсөн талбайн зааварчилгаа, биелэлтийн бүртгэл №.....

Д/д	Албан шаардлагын утга	Албан шаардлагын		Хүлээн авсан ажилтаны нэр	Биелэлтийн хугацаа		Биелэлтийн тухай дүгнэлт тэмдэглэл
		Дугаар	өгсөн он сар өдөр		Засварлаж дуусгах	Засварласан	
1	2	3	4	6	7	8	11
1							
2							
3							
4							
5							
6							

Бүртгэл хөтөлсөн

468
 18 10 22

МОНГОЛ УЛСЫН
 ЭХ ХУВЬ
 Сайд Торнин иргэдийн өмчийн дэргтэн 2018 он 228 дугаар тушаал

ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИЙН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ӨДРИЙН МЭДЭЭ

Гүйцэтгэгч:

№	Хийгдсэн ажлын нэр төрөл	Байршил		Ажлын цаг			Ажлын тоо хэмжээ	Хариуцсан инженер	Ажилд гарсан дутагдал тулгамдсан асуудлууд	Авсан арга хэмжээ
		Пикет	Урт км	Эхэлсэн	Дууссан	Нийт				
1	Далан /м3/									
2	Ухмал /м3/									
3	Х.х.үе /м3/									
4	Суурь /м3/									
5	Цацлага /м2/									
6	АБ хучилт /м3/									
7	Хөвөө /м3/									
8	Гүүр /у/м/									
9	Дөрвөлжин хоолой /м3/									
10	Дугуй хоолой /м3/									

В. Тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Х/н	Эксковатор	Бульдозер	Ачигч	Грейдэр	Индүү	Самосвал	Усны машин	Үйлчилгээний машин	Бусад	Нийт
1	Нийт тоо	ш										
	Тух/өдөр ажилласан	ш										

Г. Ажиллах хүн хүч

№	Ажиллах хүн хүч	Х/н	Замын инженер	Хийцийн инженер	Материалын инженер	Геодизийн инженер	Мастер даамал	Замчин	Жолооч	Оператор	Бусад	Нийт тоо
1	Нийт тоо	хүн										
	Тух/өдөр ажилласан	хүн										

Тайлан гаргасан:

ТАВ ТЭУЛЭЙН ЗӨГ ҮДИЙН НАМ
ХУУЛСАРТ ИЭН
18 10 2018

ЭХ ХУВЬ
2018 208

ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ

Төслийн нэр:
Зөвлөхийн нэр:
Гүйцэтгэгчийн нэр:

20... оны сарынны байрлаар

№	Ажлын төрөл	Нийт ажлын тоо хэмжээ (км/м3/ш)	Нэгж өртөг	Өмнөх 7 хоногийн байдлаар		Өссөн дүнгээр		Тухайн 7 хоногт гүйцэтгэсэн		Тухайн 7 хоногт хийсэн ажлын өртөг	Нийт ажилд эзлэх хувь
				Гүйцэтгэл (км/м3/ш)	Хувь (%)	Гүйцэтгэл (км/м3/ш)	Хувь (%)	Гүйцэтгэл (км/м3/ш)	Хувь (%)		
1	Замын чиг сэргээх										
2	Ургамалын үеийг хуулах										
3	Газар шорооны ажил										
4	Ухмал байгуулах										
5											
6											
7											
8											
9											

Б. Үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн материалын хангалт

№	Материалын нэр	Хэм/нэгж	Нийт хэрэгцээ	Материал бэлтгэлийн байдал			Нийт дүнд эзлэх хувь
				Өмнө хийгдсэн	Энэ 7 хоногт хийгдсэн	Нийт хийгдсэн	
1	Буталсан чулуу (Фракцаар)	0-5 м3					
		5-10 м3					
		10-20 м3					
2	Төмөрбетон дугуй хоолой	Ф 1м ш					
		Ф 1,5м ш					
3	Битум	тн					
4	Арматур	тн					
5	Цемент	тн					


В. Тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Хэм/нэгж	Эксковатор	Бульдозер	Ачигч	Грейдэр	Индүү	Самосвал	Усны машин	Үйлчилгээний машин	Бусад	Нийт
1	Нийт тоо	ш										
2	Тух/7хоногт ажилласан	ш										
3	Эвдэрсэн	ш										

Г. Ажиллах хүч хүч

№	Тоног төхөөрөмж	Хэм/нэгж	Жолооч	Оператор	Замчин	Геодизийн инженер	Материалын инженер	Хийцийн инженер	Замын инженер	Мастер даамал	Бусад	Нийт тоо
1	Нийт тоо	хүн										
2	Тух/7хоногт ажилласан	хүн										

Танилцуулсан:



2018 228

САРЫН ТАЙЛАН /ТОО ХЭМЖЭЭГЭЭР/

Төслийн нэр:

Зөвлөхийн нэр:

Гүйцэтгэгчийн нэр:


Огноо: 20..... оны.....сарын.....ны байдлаар

№	Ажлын төрөл	х/н	Нийт ажлын тоо хэмжээ	Өмнөх тайлангаар		Өссөн дүнгээр		Тухайн сард гүйцэтгэсэн	
				Гүйцэтгэл (км/м3/ш)	Хувь (%)	Гүйцэтгэл (км/м3/ш)	Хувь (%)	Гүйцэтгэл (км/м3/ш)	Хувь (%)
1	Хөрс хуулалт	Га/км							
2	Далангийн дүүргэлт	м3							
	i) Карьераас	м3							
	ii) Ухмалаас	м3							
3	Ухмал	м3							
	Ухмалын материал зайлуулах	м3							
	Зөөлөн материалын ухмал	м3							
4	Хөлдөлтөөс хамгаалах үе								
5	Суурь								
6	Хучилт	ш							
7	Гүүр	ш							
8	Хиймэл байгууламж								

Хянасан: Зөвлөх багийн ахлагч

Тайлан гаргасан: Тоо хэмжээний инженер

468
18 10



САРЫН ТАЙЛАН /МӨНГӨН ДҮНГЭЭР/

Төслийн нэр:

Зөвлөхийн нэр:


Гүйцэтгэгчийн нэр:

Огноо: 20..... оны.....сарын.....ны байдлаар

№	Ажлын нэр	х/н	Нийт ажлын тоо хэмжээ	Нэгж өртөг	Тухайн сард гүйцэтгэсэн ажлын		Нийт гүйцэтгэсэн ажил	Нийт өртөг
					Тоо хэмжээ	Өртөг		
1	Хөрс хуулалт ,түр зам	Га/км						
2	Далангийн дүүргэлт	м3						
	i) Карьераас	м3						
	ii) Ухмалаас	м3						
3	Ухмал	м3						
	Ухмалын материал зайлуулах	м3						
	Зөөлөн материалын ухмал	м3						
4	Хөлдөлтөөс хамагаалах үе	м3						
5	Цементээр бэхжүүлсэн суурь							
6	Асфальтобетон хучилтын ажил							
7	Гүүр	ш						
8	Хиймэл байгууламж	ш						
	Нийт дүн /НӨТ-гүй/							

Хянасан: Зөвлөх багийн ахлагч

Тайлан гаргасан: Тоо хэмжээний инженер



18 10 28

ГРАФИК ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн нэр:

Зөвлөхийн нэр:

Гүйцэтгэгчийн нэр:

Огноо: 20..... оны.....сарын.....ны байдлаар

Хугацаа Төлөвлөгөөний биелэлт			Хийх ажил								Нийт ажилд эзлэх хувь		
			Тухайн 7 хоногт				Өссөн дүнгээр				Батлагдсан төлөвлөгөөгөөр	Гүйцэтгэлээр	
			Батлагдсан Төлөвлөгөөгөөр	Гүйцэтгэл	хувь	Зөрүү биетээр /+,-/	Батлагдсан Төлөвлөгөөгөөр	Гүйцэтгэл	хувь	Зөрүү биетээр /+,-/			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
ОН	сар	7 хоног											
		7 хоног											
		7 хоног											
		7 хоног											
	сар	7 хоног											
		7 хоног											
		7 хоног											
		7 хоног											
	сар	7 хоног											
		7 хоног											
		7 хоног											
		7 хоног											

Хянасан: Зөвлөх багийн ахлагч

Тайлан гаргасан: Тоо хэмжээний инженер

468

18 10 22

МОНГОЛ УЛСЫН
ТАМ ТЭГВРИЙН ХӨГ ЖИЭНИ ЗАД
ЭХ ХУВЬ
Санд Төлөвлөгөөний биелэлтийн
дүнгээр 2019 оны 228-дугаар тусламт